

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2020 ОНЫ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН**

2021.03.24


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” /цаашид “журам” гэх/-ын 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, цахим тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн үнэлгээ өгсөн болно.

Худалдан авах ажиллагааны 2020 оны тайланг 14 яам, нийслэл, 21 аймаг болон бусад 19 байгууллага бүхий нийт 55 төсвийн ерөнхийлөн захирагч ирүүлэхээс 49 төсвийн ерөнхийлөн захирагч ирүүлсэн байна. Үүнээс Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол банкны ерөнхийлөгч тайлан ирүүлээгүй, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах үндэсний комиссын даргын багц тухайн онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй тухай албан бичиг ирүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Соёлын яамны худалдан авах ажиллагааг үнэлэх боломжгүй байсан болно.


Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2020 онд нийт 4,706.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, нийт 3,547.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулж ажилласан байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх нийт 785 төсөл, арга хэмжээнд 1,330.8 тэрбум төгрөг батлагдаж 1,093.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 82.17 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын үнэлгээний талаар:


Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Архангай аймгийн Засаг дарга, Баянхонгор аймгийн Засаг дарга, Говьсүмбэр аймгийн Засаг дарга, Дархан-Уул аймгийн Засаг дарга, Дорноговь аймгийн Засаг дарга, Дорнод аймгийн Засаг дарга, Орхон аймгийн Засаг дарга, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Төв аймгийн Засаг дарга, Увс аймгийн Засаг дарга, Ховд аймгийн Засаг дарга, Хөвсгөл аймгийн Засаг дарга, Хэнтий аймгийн Засаг дарга, Үндэсний статистикийн газрын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Улсын ерөнхий прокурор, Монгол Улсын ерөнхий аудитор, Үндсэн хуулийн цэцийн дарга нар 80-89 хувь буюу “Сайн”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монгол Улсын Ерөнхий сайдын багц, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд, Монгол Улсын Шадар сайдын багц, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Гадаад харилцааны сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Баян-Өлгий аймгийн Засаг дарга, Булган аймгийн Засаг дарга, Говь-Алтай аймгийн Засаг дарга, Дундговь аймгийн Засаг дарга, Завхан аймгийн Засаг дарга, Өвөрхангай аймгийн Засаг дарга, Нийслэлийн Засаг дарга, Өмнөговь аймгийн Засаг дарга, Сүхбаатар аймгийн Засаг дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч нар 60-79 хувь буюу “Хангалттай”, Барилга, хот байгуулалтын сайд, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга нар 40-59 хувь буюу “Хангалтгүй” үнэлгээ тус тус авсан байна.



Үүнээс тайлан ирүүлээгүй 2, хөрөнгө оруулалт батлагдаагүй 2, үнэлэх боломжгүй 2 нийт 6 төсвийн ерөнхийлөн захирагчийг үнэлгээнд хамруулаагүй болно. Соёлын сайдын багцад батлагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөгөө Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /хуучин нэрээр/ баталсан бөгөөд худалдан авах ажиллагааг Боловсрол шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан тул үнэлгээнд хамруулаагүй болно. **Улсын хэмжээнд 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн дундаж 73 хувь буюу “Хангалттай” гэж үнэлэгдлээ.**



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017-2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээг сайд, Засаг дарга болон бусад буюу Монгол Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг, шүүхийн байгууллагууд тус бүрээр танилцуулбал:




Дээрх графикаас харахад 2020 онд яамдын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн дундаж нь 71 хувь, нийслэл, аймгууд 78 хувь, харин бусад төсвийн ерөнхийлөн захирагчид 72 хувь буюу “Хангалттай” гэж үнэлэгдсэн байна.

Орон нутагт худалдан авах ажиллагааны мэргэжлийн нэгж Засаг даргын төсвийн багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэж байгаа тул бусад төсвийн ерөнхийлөн захирагчдаас өндөр үнэлгээ авахад нөлөөлж байна.

Худалдан авах ажиллагааны холбогдох журмыг баримталсан байдал:

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2020 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт **3,547.6** тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс **63.45** хувь буюу **2.3** их наяд төгрөгийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, **3.96** хувь буюу **140.5** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, **1.72** хувь буюу **60.1** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар, **29.5** хувь буюу **1.05** их наяд төгрөгийн худалдан авах ажиллагааг гэрээ шууд байгуулах аргаар, **0.82** хувь буюу **29.1** тэрбум төгрөгийг шууд худалдан авалтаар, **0.5** хувь буюу **18.3** тэрбум төгрөгийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмаар, **0.03** хувь буюу **0.97** тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тус тус хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд нийт 15,651 тендер шалгаруулалт зохион байгуулж үүнээс 5,087 нээлттэй тендер шалгаруулалт, 3,995 харьцуулалт, 1,395 гэрээ шууд байгуулах, 471 хязгаарлагдмал тендер шалгаруулалт, 4,321 шууд худалдан авалт, 83 олон нийтийн оролцоотой, 299 зөвлөх үйлчилгээний журмаар тус тус тендер шалгаруулалт зохион байгуулж гэрээ байгуулсан байна.



Тайлант хугацаанд нийт 16,524 тендер шалгаруулалт зохион байгуулснаас 5,481 нээлттэй тендер шалгаруулалт, 4,261 харьцуулалт, 1,389 гэрээ шууд байгуулах, 456 хязгаарлагдмал тендер шалгаруулалт, 4,490 шууд худалдан авалт, 87 олон нийтийн оролцоотой, 360 зөвлөх үйлчилгээний журмаар тус тус зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан байдал:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим сүлжээнд тухай бүр зарлахаар хуульчилсан.

Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийг боловсруулан 2017 оноос бүх шатны төрийн байгууллагууд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ашиглаж байна.

Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт /2018-2020 он/



Тайлант хугацаанд нийт тендер шалгаруулалтын 99 хувийг цахим системээр зохион байгуулсан байна.

2020 онд худалдан авах ажиллагааны цахим системд 2,387 захиалагч байгууллагаас 29,072 худалдан авах ажиллагаа хэрэгжүүлэхээр нэгдсэн төлөвлөгөө баталж, нийтэлсэн. Үүнээс худалдан авах ажиллагааны цахим системд давхардсан тоогоор 22,598 цахим тендер шалгаруулалтын урилга зарласан ба 831 зөвлөх үйлчилгээний санал ирүүлэх зарлалыг нээлттэй мэдээлсэн байна. Цахим системд 13,131 аж ахуйн нэгж бүртгүүлэн цахим тендер шалгаруулалтад оролцсон байна.

Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.2.7-д “Үнэлгээний хороо хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендер оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам”-ын дагуу ил болгох.” гэж заасан байдаг.

2020 онд зарласан 22,598 цахим тендер шалгаруулалтаас 19,807 тендер шалгаруулалтын үр дүн 91 хувийг олон нийтэд мэдээлэн ажилласан байна. Захиалагч байгууллагууд тендер шалгаруулалтын урилгыг зарлаж, цахим тендер шалгаруулалтад тендер оролцогчд оролцож хэвшсэн байгаа хэдий ч тендер шалгаруулалтын үр дүнг эцсийн шийдвэр гарсан өдөрт нь оруулахгүй зөрчил нийтлэг байна. Хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш дунджаар 13 хоногоор хоцорч үр дүн оруулсан мэдээлсэн байна. Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэхгүй байгаа нь томоохон зөрчил бөгөөд худалдан авах ажиллагааны ил тод байдлыг алдагдуулах эрсдэлтэй тул дээрх зөрчлийг арилгах шаардлагатай байна. Нөгөө талаас цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг оруулахгүй байх нь Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам”-ын дагуу тендер оролцогч шалгарсан оролцогчийн тендертэй танилцах боломжийг хааж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар харьяа төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэр, аж ахуйн тооцоотой газар, хуулийн этгээдийн 2020 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн ирүүлэхгүй байгаа нь дээрх тоо мэдээ Худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн мэдээнээс зөрүүтэй тайлагнах гол шалтгаан болж байна. Иймд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, үнэлэх журмыг өөрчилж зөвхөн цахим хэлбэрээр тайлангийн өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна.

Цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, улсын хэмжээний тоон мэдээг нэг эх үүсвэрээс авах зорилгоор худалдан авах ажиллагааны явцын болон жилийн эцсийн тайланг системд үндэслэн нэгтгэж байна.


Хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтад “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд захиалагч байгууллагуудыг гэрээний мэдээллийг оруулах боломжийг бүрдүүлсэн бөгөөд 2020 онд 15,620 гэрээний мэдээлэл бүртгэгдээд байна.

Цаашид худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж төрийн байгууллага болон тендерт оролцогч нарын хооронд байгуулсан гэрээний хуулбарыг цахим системд нийтэлж байх нь тухайн тендерт оролцогчийн чадавхыг үнэлэхэд дөхөм болгох ач холбогдолтой бөгөөд төсвийн хөрөнгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл олон нийтэд ил болж, иргэд, хөндлөнгийн байгууллагаас тавих хяналт сайжирна.

Тендерт оролцогч нараас гаргасан гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54, 55, 56 дугаар зүйлд худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тендерт оролцогчдын гомдол гаргахдаа аль шатанд ямар байгууллагад хандахыг тодорхой зааж өгсөн байдаг.

2020 онд эдгээр байгууллагуудад тендер шалгаруулалттай холбоотой нийт 1,271 гомдол гарсан бөгөөд үүнээс 154 гомдол буюу 12 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, 1,009 буюу 79 хувь нь захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр Сангийн яаманд, 108 буюу 8 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.




Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногт хянан хариу өгдөг.

2020 онд Сангийн яам 816 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 560 аж ахуйн нэгжээс давхардсан тоогоор нийт 1,009 гомдлыг хянан шийдвэрлэсэн. Хүлээн авсан нийт гомдлын 134 буюу 13 хувийг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 184 гомдлоор багассан байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх **590** шийдвэр, тендер шалгаруулалтыг хүчингүй болгох **71** шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендер оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

Сангийн яаманд тендер оролцогч тендерийн баталгаагаа барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах хуулийн зохицуулалтын дагуу 2020 онд 38 үндэслэлгүй гомдолд барьцаалсан 211,030,855.23 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгох шийдвэр гаргаж, Төрийн сангийн 100900000753 тоот “Тендерийн баталгааны орлого” дансанд төвлөрүүлсэн байна.



Гэрээ байгуулахын өмнөх шатанд захиалагчийн шийдвэрт тендер оролцогчдоос гаргасан гомдол болон гомдлыг хянан үзээд захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэр гаргасан болохыг тогтоосон шийдвэрийн тоо өмнөх онтой харьцуулахад буурахгүй байна.

Тендер оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын 58 хувь нь үндэслэлтэй байна.

Энэ нь үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ зохих хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаагүй, нөгөө талаас захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Цаашид захиалагч хуулийн 46 дугаар зүйлд заасан үүргийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Гомдол шийдвэрлэлтийн бусад төрөлд Сангийн яам гомдлыг хүлээн авах боломжгүй, гомдлын бүрдүүлбэр шаардлага хангахгүй, гомдол гаргах хугацаанд тус яаманд хандаагүй, захиалагч байгууллага гэрээ байгуулсан, эсхүл гаргасан гомдлыг эргүүлэн татсан шийдвэрүүдийг багтаасан. Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт “Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендер оролцогч дахин гомдол гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана.” гэж заасны дагуу буцаасан болон шүүхэд хандах 105 гомдол, гаргасан гомдлыг эргүүлэн татсан 35, захиалагчид гомдол гаргах 8, бүрдүүлбэрийн шаардлага хангаагүй, хуульд заасан хугацаа дууссан 137 гомдол байсан болно.

Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн талаар:

Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталж хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6, 14.1.7 дахь заалтад заасан нөхцөл үүссэн эсэхийг улсын байцаагчаар дамжуулан хяналт шалгалт хийх ажлыг сэргээгээд байна.

Худалдан авах ажиллагааны ерөнхий байцаагчийн удирдамжийн дагуу захиалагч байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн нотлох баримт дээр үндэслэн 2020 онд 19 аж ахуйн нэгжийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулаад байна.

Нийт 31 аж ахуйн нэгж “Дээвэрконстракшн” ХХК, “Мөнх цаст жаргалант” ХХК, “Эс жи эм” ХХК, “Экотогтол” ХХК, “Ди Ди Эм Эс Глобал” ХХК, “Аяга-Уул” ХХК, “Баттод” ХХК, “Тотал технологи” ХХК, “Метро консалтинг” ХХК, “Тэгш өргөө” ХХК, “Мөлүүхээр” ХХК, “Кристалхилл капитал” ХХК “Бүрд-Уул” ХХК, “Тэрхийн ундраа” ХХК, “Монголдайвин” ХХК, “Гэрэлтөсөл” ХХК, “Жиди” ХХК, “Меговатт” ХХК, “Баянмогод” ХХК, “Ханлиг-Илч” ХХК, “Баянбалбар” ХХК, “Футурвижн” ХХК, “Миланд агро” ХХК, “Төгсцас” ХХК, “Эврест ланд групп” ХХК, “Ай Си Би Си” ХХК, “ГЭСАК” ХХК, “Аминхүү констракшн” ХХК, “Интерном” ХХК, “Бумбатхоолой” ХХК-илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг худалдан авах ажиллагааны улсын байцаагч тогтоосон байна.

Дээрх аж ахуйн нэгжүүдийн тендерт оролцох эрхийг 3 жилээр хассан бөгөөд жагсаалтыг Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /<https://www.tender.gov.mn/mn/bidder/blacklist/>-д мэдээлэн ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны сургалтын талаар:

Хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хорооны бүх гишүүдэд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. 2020 онд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтын шалгалтад 4,807 суралцагч бүртгүүлж, 359 удаагийн шалгалтад 2,897 суралцагч тэнцэж нийт гэрчилгээ эзэмшигчдийн тоо 12,807 болоод байна.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг цаасаар олгохыг зогсоож зөвхөн цахим систем /www.tender.gov.mn/mn/exam/certificate/-ээр дамжуулан шалгалтад тэнцсэн тухайн өдрөө гэрчилгээг гардан авах боломжтой болсон. Гэрчилгээг системээр дамжуулан олгох нь Төрийн худалдан авах ажиллагааны газар болон гэрчилгээ авахаар ирдэг иргэдийн зардал, ачааллыг бууруулах юм.

Түүнчлэн хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт үнэлгээний хороонд орж ажиллах иргэн, төрийн бус байгууллагын төлөөллийг тэднийг төрийн зардлаар мэргэшүүлж сургах ажлын хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Цахим сургалтын систем /www.surgalt.tender.gov.mn/-ийг ашиглалтад орууллаа.

Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-д гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссан ажилтнууд давтан танхимын сургалтад хамрагдалгүйгээр хугацааг сунгах боломжийг олгосон. Цар тахлын онцгой дэглэмийн хүрээнд танхимын сургалтын үйл ажиллагааг хязгаарласнаас хойш цахим сургалтад хамрагдах иргэдийн идэвх нэмэгдэж байна.


Зөрчил, дутагдал:

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дараах нийтлэг зөрчил, дутагдлууд илэрсэн. Үүнд:


1. Цахим системд 2020 онд хэрэгжүүлэхээр 29,072 худалдан авах ажиллагаа төлөвлөсөн боловч 13,460 төсөл, арга хэмжээг зохион байгуулснаас үзэхэд худалдан авах ажиллагааны төлөвлөлт бодитой бус, тухайн онд хэрэгжихгүй төсөл, арга хэмжээг олноор төлөвлөж байгаа нь төлөвлөлт, гүйцэтгэл зөрөх үндсэн шалтгаан болж байна;
2. Цахим системд 2020 онд 21,747 тендер шалгаруулалтын урилгыг нийтэлснээс 19,807 тендер шалгаруулалтын үр дүн нийтэлсэн ба хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг зөрчиж тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нийтлэхгүй байх, хугацаа хоцроох буюу жилийн төгсгөлд мэдээлж байна;
3. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулдаггүй;
4. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр ирүүлдэггүй;
5. Сангийн яаманд ирсэн гомдлын дийлэнх буюу 58 хувь нь захиалагч хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэсэн хариу гарч байгаагаас дүгнэхэд үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ хууль, журмыг зөрчсөн, үндэслэлгүй шийдвэр гаргах, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавихгүй байгаа нь захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтын биелэлт хангалтгүй;
6. Улирлын чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаандаа зохион байгуулахгүй байгаа нийтлэг зөрчил нь хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл /2014-2020/

*Нийт худалдан авалт
/тендер шалгаруулалтын журам, арга/*



*Нийт худалдан авалт
/төсвийн ерөнхийлөн захирагчдаар/*



Хавсралт 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний нэгдсэн дүн

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	2015 оны үнэлгээ /хувиар/	2016 оны үнэлгээ /хувиар/	2017 оны үнэлгээ /хувиар/	2018 оны үнэлгээ /хувиар/	2019 оны үнэлгээ /хувиар/	2020 оны үнэлгээ /хувиар/
Яамд							
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	49	35	72.5	73.3	84	60
2.	Барилга, хот байгуулалтын сайд	37	23	59.6	48.5	79	51
3.	Зам тээврийн хөгжлийн сайд	36.5	33	92	81.6	67	61
4.	Батлан хамгаалахын сайд	35	25	60	82.3	80	81
5.	Боловсрол, шинжлэх ухааны сайд	46	25	60	52.2	43	71
6.	Гадаад харилцааны сайд	35	61,3	58.1	63.7	68	73
7.	Сангийн сайд	62	50	73.8	75.5	70	87
8.	Соёлын сайд						-
9.	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд	40	40	72.5	67.0	84	77
10.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	62	42	69.1	58.9	60	62
11.	Хууль зүй, дотоод хэргийн сайд	62	51.5	84.3	86.0	81	88
12.	Эрүүл мэндийн сайд	60	37	68.8	71.6	77	67
13.	Эрчим хүчний сайд	60	46	68.9	58.8	71	71
14.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	60	66.9	84.8	73.3	71	77
	Дунджаар	48	42.6	71.1	68.7	72	71
Аймаг							
15.	Архангай аймгийн Засаг дарга	80	83.5	72.5	84.0	67	80
16.	Баян-Өлгий аймгийн Засаг дарга	48	51.4	76.3	72.9	68	79
17.	Баянхонгор аймгийн Засаг дарга	69	68.0	71.3	80.5	79	80
18.	Булган аймгийн Засаг дарга	62	59.0	66.3	70.0	53	67
19.	Говь-Алтай аймгийн Засаг дарга	0	60.0	94.9	84.4	82	72
20.	Говьсүмбэр аймгийн Засаг дарга	70	61.6	88.8	83.3	80	83
21.	Дархан-Уул аймгийн Засаг дарга	65	61.9	84.4	89.4	84	83
22.	Дорноговь аймгийн Засаг дарга	80	65.5	89.4	86.7	84	81
23.	Дорнод аймгийн Засаг дарга	52	66.5	84.5	85.0	67	82
24.	Дундговь аймгийн Засаг дарга	55	61.0	85.0	82.2	78	68
25.	Завхан аймгийн Засаг дарга	46	62.0	76.3	74.4	79	77
26.	Нийслэлийн Засаг дарга	60.5	12.0	71.3	74.3	62	65
27.	Орхон аймгийн Засаг дарга	93	90	90.3	92.2	84	84
28.	Өвөрхангай аймгийн Засаг дарга	58	61	73.1	77.5	74	69
29.	Өмнөговь аймгийн Засаг дарга	48	48	86.3	73.3	80	63
30.	Сүхбаатар аймгийн Засаг дарга	60	57.5	80.0	85.1	86	76
31.	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	65.5	76	81.3	81.0	81	82
32.	Төв аймгийн Засаг дарга	60.5	57	67.5	88.0	88	82
33.	Увс аймгийн Засаг дарга	73	71	81.4	80.6	80	80
34.	Ховд аймгийн Засаг дарга	60	58.5	85.0	78.9	87	83
35.	Хөвсгөл аймгийн Засаг дарга	71.5	84.5	96.9	87.0	84	86
36.	Хэнтий аймгийн Засаг дарга	69	66	92.3	84.4	86	88
	Дунджаар	63.6	62.8	81.6	84.5	78	78
Бусад							
37.	Авлигатай тэмцэх газрын дарга	53	**	**	81.0	80	87
38.	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	**	0	0	**	**	**
39.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	**	27	77.1	82.7	78	86
40.	Монгол Улсын Ерөнхий сайдын багц	**	27	75.0	83.8	70	70
41.	Монгол Улсын Их Хурлын Тамгын газар	**	38	60.0	**	**	0
42.	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	**	0	19.2	80.0	87	68
43.	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	**	**	60.8	54.2	80	84
44.	Төрийн албаны зөвлөлийн дарга	**	**	0	**	**	75
45.	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах үндэсний комиссын дарга	**	**	**	**	**	**
46.	Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	**	80	73.8	80.0	83	78

47.	Улсын Ерөнхий прокурор	74	80	41.7	63.5	74	83
48.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	**	0	**	71.6	60	85
49.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	**	**	0	**	**	**
50.	Монгол Улсын Ерөнхий аудитор	53.5	46	0	60.0	60	80
51.	Үндэсний статистикийн хорооны дарга	81	**	61.4	71.6	49	88
52.	Хүний эрхийн Үндэсний комиссын дарга	**	**	**	**	**	47
53.	Монгол Улсын Шадар сайд	50.5	38	75.0	74.4	80	63
54.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	61	64	88.1	73.9	84	61
55.	Монголбанкны ерөнхийлөгч	0	0	0	0	0	0
Дунджаар		61.6	54.1	63.2	72.0	68	72
Нийт дундаж хувь		58	56.0	72.0	75.0	73	73

** - Худалдан авалт байхгүй.

0 - Тайлан ирүүлээгүй.